



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдөр, зам, тээврийн болон бусад салбар, байгууллагын ойг тэмдэглэхтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс мөнгөн шагнал, урамшуулал, хандив, бэлэг, бусад санхүүгийн туслалцаа авах, авахыг хүссэн албан бичиг явуулахыг зогсоохыг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга болон газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Зам, тээврийн болон бусад салбарын тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэхдээ Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам”-ыг хатуу мөрдөж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Батзаяа/ болон тус яамны харъяа агентлаг, байгууллагын дарга нарт даалгасугай.



А.ГАНСҮХ